



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-51) 26 44 44, Факс: (976-51) 26 41 24,
Цахим шуудан: info@frc.mn, Цахим хуудас: www.frc.mn

2025.08.12 № 1/3066
таний -ны № -т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН П.САЙНЗОРИГ ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Таны 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 27 дугаар албан бичгээр ирүүлсэн асуулттай танилцлаа.

Банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо нь зээлийн хүүгийн хэмжээг бодож, тооцоходоо Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 21.3-д заасны дагуу Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны А-106/298 дугаар тушаалаар хамтран баталсан “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, зээлийн хүүгийн хэмжээг бodoх, тооцох, мэдээллийн ил тод байдлыг хангах аргачлал”-ыг баримтлан ажилладаг.

Зээлийн хүүгийн бодит өртөг нь зээлдэгчээр төлгүүлж буй зээлийн зарласан хүү, шимтгэл, хураамж, бусад нэмэлт зардлыг багтаасан дүн бөгөөд дээрх аргачлалын 3.4-д заасны дагуу зээлдүүлэгч нь зээлийн хүсэлт хүлээн авах, судлах, олгох, олгосны дараах хяналттай холбоотой бүх төрлийн шимтгэл хураамж, даатгалын үйлчилгээнд төлөх хураамж, зээлийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зээлдэгчийн гуравдагч этгээдэд төлөх үйлчилгээний төлбөр зэргийг зээл судлах үед болон зээл олгосноос хойш 1 жилийн хугацаанд зээлдэгчийн зээлийн бодит өртөгт оруулах талаар зээл хүсэгчид танилцуулах, 3.5-д танилцуулсан зээлийн бодит өртгийн хувьд зээл олгох шийдвэр гарсны дараа өөрчлөлт орсон тохиолдолд шалтгааныг тайлбарлаж, зээл хүсэгч хүлээн зөвшөөрсөн тохиолдолд зээл олгохоор тус тус зохицуулсан.

Мөн дээрх хуулийн 6.6-д “Банк, эрх бүхий хуулийн этгээд өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн хувь, хэмжээг үндэслэлтэй тогтоох бөгөөд үүнд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавина.” гэж заасны дагуу зээлдүүлэгч бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн хувь хэмжээг үйл ажиллагааны зардал болон бусад хүчин зүйлсийг харгалzan тогтоодог.

Харин мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчийн хувьд Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 15.10-д “Зээлийн, барьцааны болон батлан даалтын гэрээ байгуулахад аливаа шимтгэл, хураамж, эсхүл нэмэлт төлбөр авахыг мөнгөн зээлийн

үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хориглоно.” гэж заасны дагуу аливаа хэлбэрээр шимтгэл, хураамж авахыг хориглосон зохицуулалттай байна.

Санхүүгийн зохицуулах хороо зээлийн хүү, шимтгэлтэй холбоотойгоор 2022 оноос хойших хугацаанд нийт 50 өргөдөл, гомдлыг хүлээн авснаас 4 хувь нь шимтгэл, хураамжтай холбоотой бөгөөд хадгаламж, зээлийн хоршооны зээлийн хүү, шимтгэл, хураамжтай холбоотой өргөдөл гомдол бүртгэгдээгүй байна.

Он	Нийт	Зээлийн хүүтэй холбоотой		Шимтгэл, хураамж	
		Банк бус санхүүгийн байгууллага	Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч	Банк бус санхүүгийн байгууллага	Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч
2022	13	11		2	
2023	8	8		0	
2024	6	6		0	
2025. 06.30-ны байдлаар	23	13	8	2	

Санхүүгийн зохицуулах хорооноос хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх замаар иргээдэд зохицуулалтын байгууллагуудаас зээл авахад анхаарах зүйлс, үүсэх үр дагавар зэрэг хууль эрх зүйн мэдлэг олгох ажлыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулан ажиллаж байна. Мөн хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийн хүрээнд зээлдэгч, иргээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлүүлэх, тэдгээрийг төлөөлж шүүхийн байгууллагад хандах, эрх ашиг нь зөрчигдсөн хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн хохирлыг барагдуулах зэрэг арга хэмжээг авч байна.

Цаашид санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох зорилгоор салбарын зохицуулалтын хуулиуд болох Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Санхүүгийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд холбогдох зохицуулалтыг тусгаад байна.

Хүндэтгэсэн,

